

ИРГЭН ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ ОРОЛЦОГЧ БОЛОХ НЬ

Нийгэм судлал 10-р анги

Багш Д.Уранцэцэг

III улирал.

Email: D.Urantsetseg 55@yahoo.com

Утас: 99291533

ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

- ❑ Иргэний улсаа төлөөлөгч болохын бодит жишээ, тохиолдлыг шинжилж, мэдээлэл цуглуулах.
- ❑ Олон Улсын иргэний эрх зүйн талаар мэдлэгтэй болох.
- ❑ Ялтан шилжүүлэх тухай конвенцын талаар ойлголт авах

ТУЛГУУР ОЙЛГОЛТ

Ялтан нь ял эдлүүлэх улсын иргэн байх.

Иргэний эрх /Үндсэн хууль 16- зүйлийн 18-д/ Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно.

МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

- 1.Гадаад улсад суугаа иргэдийн эрхийг хамгаалах

Олон улсын гэрээний хүрээнд хамгаалах

Туслалцаа, дэмжлэг үзүүлэх

- 2.Гадаад улсад суугаа иргэдэд шаардлага тай үед туслалцаа , дэмжлэг үзүүлэх

- 3.Иргэн хүнд өвчин тусах, нас барах зэрэг тохиолдолд дэмжлэг шуурхай үзүүлэх

Гэнэтийн халдлага, аюул, албадлагад өртөх

Олон улсын байгууллага тай хамтран ажиллах;

- 4.Гадаадад зорчиж байгаа иргэдийг хар тамхи, хүний наймаа зэрэг ийм төрлийн хэрэгт холбогдож хохирогсдын эрхийг хамгаалах

- 5.Гадаада д байгаа иргэддээ тэдний хууль ёсны мэдээлэл, зөвлөлгөө өгч байх

хууль ёсны эрх, эрх чөлөө, үүрэг

Үйл ажиллагааг дэмжих

- 6.Гадаада д буй иргэдийн үүсгэл санаачилгыг дэмжиж ажиллах

ИРГЭН ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ ОРОЛЦОГЧ

Олон Улсын харилцаанд иргэд хоорондын харилцааг Олон Улсын иргэний эрх зүй зохицуулдаг. Иргэд хоорондын харилцаанд өмчлөх, өвлөх, гэр бүл, хөдөлмөрийн харилцаа зонхилдог. Монгол улсын иргэд дэлхийн улс орнуудын алинд нь ч зорчих, сурах, амьдрах эрхтэй болсон. Тиймээс Монгол хүний аюулгүй байдал, иргэний үндсэн эрхийг хамгаалах асуудал улс хоорондын харилцаанд нэн чухалд тооцогддог. Монгол улсын хилийн чанадад байгаа иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, эрх ашгийг хамгаалах нь төрийн бодлогын гол зорилгын нэг юм.

Олон улсын харилцаанд оролцогчдыг үйл ажиллагааны хамрах хүрээгээр нь 3 ангилна




ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНИЙ МАСТЕР Г.ОТГОНЦЭЦЭГ



2014 онд ОУХМ Г.Отгонцэцэг Казахстан улсын шигшээ багт анх удаа уригдаж, тус улсын нэрийн өмнөөс “Рио-2016” олимпоос хүрэл медаль хүртсэн юм. Тэрээр жүдо бөхийн эмэгтэйчүүдийн 48 кг-д дэлхийн чансааг тэргүүлж байна.

НОБЕЛИЙН ЭНХ ТАЙВНЫ ШАГНАЛТ МАЛАЛА ЮСУФЗАЙ



Малала Юсуфзай Британийн "BBC"-гийн вэб хуудсанд блог хөтөлж охидод боловсрол олгохын төлөө тэмцэж байсан юм. Талибанчууд охидыг сургуульд явахыг хориглосон. Тэд 2007 оноос хойш 122 мянган охид сурдаг сургуулийг сүйтгэсэн. 2012 оны есдүгээр сарын 2нд Малалаг сургуулиасаа буцах замд Талибанчууд гал нээж, алахыг завдсан. Тэрээр 2013 онд Нью-Йоркт НҮБ-ын индрээс үг хэлсэн. 2014 онд Нобелийн энх тайвны шагналыг 17 настайдаа хүртсэн.

БИЕ ДААЖ ХИЙХ ДААЛГАВАР-1

Дараах асуултад хариулж бичээрэй

- 1.Г.Отгонцэцэг , Малала нар Олон Улсын харилцаанд хэрхэн оролцож байна вэ?
2. Та нар Монгол улсын иргэний хувьд гадаадад улсаа хэрхэн төлөөлж болох вэ?

БИЕ ДААЖ ХИЙХ ДААЛГАВАР-2

“Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс хоорондын гэрээ”-ний төслийг хэлэлцэн дэмжээд УИХ-ын Байнгын хороотой зөвшилцөж, Ерөнхий сайдын захирамжийг баталлаа. Бүгд Найрамдах Казахстан Улсад Монгол Улсын 1000 орчим иргэн байнга оршин сууж, жилд дунджаар 6000 гаруй иргэн зорчиж байна. Одоогийн байдлаар Бүгд Найрамдах Казахстан Улсад шүүхээр ял шийтгүүлэн хорих ял эдэлж буй Монгол Улсын 3 иргэн байна. Ялтан шилжүүлэх тухай гэрээ байгуулснаар эх орондоо ял эдлэхийг хүссэн хоёр улсын иргэдийг шилжүүлэх ажиллагааг тодорхой журмын дагуу цаг алдалгүй гүйцэтгэх эрх зүйн орчин бүрдэх юм.

Эх сурвалж: <http://www.ikon.mn/n/eqj>

- 1.Төрийн зүгээс ямар үйлчилгээ үзүүлж болох вэ?
- 2.Ялтан шилжүүлэх асуудлыг өөрөөр хэрхэн шийдвэрлэж болох вэ?

БИЕ ДААЖ ХИЙХ ДААЛГАВАР-3

Дараах хүснэгтийг нөхөж бичээрэй

№	“Улс” ба “Улс бус” оролцогчид	Үүрэг	Жишээ
1	Иргэн		
2	Төр		
3	Төрийн байгууллага		
4	Аж ахуйн нэгж		
5	Төрийн бус байгууллага		

ГЭРИЙН ДААЛГАВАР

1. Бие дааж хийх даалгавар 1,2,3-г дэвтэртээ хийгээрэй.
2. Сурах бичгийн 126-128 хуудсыг сайн уншиж судлаарай.